

Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих, туслах, хамгаалахад яагаад алтан бүчийг бэлэг тэмдэг болгож байгаа вэ ?

Утга санаа ба зорилго:

Алтан бүч бол хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих, хамгаалахыг илэрхийлсэн бэлэг тэмдэг.

Алтан шар өнгө бол 6 сар хүртэлх насны хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох нь нялхас бага насны хүүхдийн алтан стандарт гэдгийг илэрхийлсэн.

Бүч бүрийн хэсэг болгон нь өөр өөр утга санааг илэрхийлнэ.

Бүчийн нэг гогцоо нь ээж, нөгөө гогцоо нь хүүхдийг илэрхийлж байна.

Тууз бол тэгшхэмтэй, эх хүүхэд хоёрыг хоёул хөхөө хөхөх болон хөхүүлэхэд тэдэнд ямагт дэмжлэг хэрэгтэйг

Зангилаа бол аав, гэр бүл, нийгэм хамт олон. Зангилаагүйгээр бүч байж болохгүйтэй адил ямар нэг дэмжлэггүйгээр хөхөөр хооллолт амжилттай байж чадахгүйг илэрхийлнэ.

Өнгөт тууз бол ирээдүй. Нэг нь 2 нас хүртэл болон түүнээс цааш нэмэгдэл хоолны зэрэгцээ үргэлжлүүлэн хөхүүлэх, нөгөө нь дараагийн жирэмслэлтийн хоорондын зайг уртасгах, магадгүй 3-5 жил, эх хүүхэд хоёрыг хамт байх, цаашид хүүхдийг эрүүл саруул өсч бойжиход халамж анхаарал тавих, хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжихэд эх хүүхэд хамт байхын чухлыг илэрхийлсэн юм.